



АЖЛЫН ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ / 15 ХУУДАС/

ТАНИЛЦСАН:  Д.МЯНГАНБААТАР  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ЗАХИРАЛ

 Ц.ОДХҮҮ  
СТРАТЕГИ, САНХҮҮ БОРЛУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:  А. ЭНХБУЛАГ  
ХАБЭАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:  Б.СОЛОНГО  
ХАБЭАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Тендерт оролцогч нь тусгай зориулалтын ажлын хувцасыг нийлүүлэхдээ МХС ХХК-ийн “*Тусгай зориулалтын ажлын хувцас нийлүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага*”-ыг мөрдлөг болгоно.
  - Тендерт оролцогч нь дараах нэр бүхий тусгай зориулалтын ажлын хувцасыг нийлүүлнэ.
- Үүнд:
- Тусгай зориулалтын зуны ажлын хувцасны хослол
  - Тусгай зориулалтын өвлийн ажлын хувцасны хослол
  - Ажлын халад
  - Ажлын хантааз /жилет/
  - Үйлчлэгчийн ажлын хувцасны хослол
- 2024 онд МХС ХХК-д шаардлагатай тусгай зориулалтын ажлын хувцасны тоог дараах хүснэгтээр харуулав. /Хүснэгт 1/

### Тусгай зориулалтын ажлын хувцасны нэр төрөл, тоо хэмжээ

*Хүснэгт 1*

No	Бүтээгдэхүүний нэр	Тоо хэмжээ /ширхэгээр/
1	Тусгай зориулалтын зуны ажлын хувцас	382
2	Тусгай зориулалтын өвлийн ажлын хувцасны хослол	377
3	Ажлын халад	37
4	Ажлын хантааз буюу жилет	148
5	Үйлчлэгчийн ажлын хувцасны хослол	31

#### 4. Тусгай зориулалтын ажлын хувцасны өнгө:

##### 4.1 : Материалын тодорхойлолт:

- Тусгай зориулалтын ажлын хувцасны ажилчидын хувцасны үндсэн материал-Тод цэнхэр PANTONE /19-4052 TCX, classic blue/, хосолгоо материал хар хөх PANTONE /19-3815 TCX, evening blue/ өнгөтэй байна.
- Тусгай зориулалтын ажлын хувцасны ИТАжилчидын хувцасны үндсэн материал-Тод цэнхэр PANTONE /19-4052 TCX, classic blue/, хосолгоо материал цайвар саарал PANTONE /13-4303 TCX, dawn blue/ өнгөтэй байна.

*Хүснэгт-3*

Мэргэжлийн анги	Хүрэм өнгө	Хантааз өнгө	Хосолгоо өнгө	Эмд өнгө	Халад өнгө	Шамц өнгө	Жишиг зураг
Тусгай зориулалтын ажлын хувцсаар	Тод цэнхэр	Хар хөх	Тод цэнхэр	-	-	-	Хавсралт2 Хавсралт4

хангагдах ажилчид						Хавсралт5
Тусгай зориулалтын ажлын хувцсаар хангагдах ИТА	Тод цэнхэр	Цайвар саарал	Тод цэнхэр	-	-	Хавсралт1 Хавсралт3 Хавсралт5
Техникийн ажилчид	-	-	-	Цайвар цэнхэр	-	Хавсралт6
Үйлчилгээний ажилчид	-	-	Хар	-	Тод цэнхэр	Хавсралт7

5. Тусгай зориулалтын ажлын хувцасыг 1 жилийн хугацаанд захиалагчтай тохирсон хуваарийн дагуу нийлүүлэх ба тусгай зориулалтын зуны ажлын хувцасыг 5 сарын 15-ны дотор, тусгай зориулалтын өвлийн ажлын хувцасыг 10 сарын 15-ны дотор тус тус нийлүүлнэ.
6. Дэлгэрэнгүй шаардлагыг “*Тусгай зориулалтын ажлын хувцас нийлүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага*”-аас харна.

### **ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АЖЛЫН ХУВЦАС НИЙЛҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

1. **ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АЖЛЫН ХУВЦАС** нь MNS ISO 13688:2000 стандартын шаардлагад нийцсэн байх бөгөөд үйлдвэрлэгчийн чанарын баталгаатай байна.
  - 1.1. Тусгай зориулалтын ажлын хувцасны материал, өнгө, загвар нь уламжлал болон хадгалагдах бөгөөд зайлшгүй тохиолдолд материал, өнгө, загварын өөрчлөлтийг компанийн хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөр хэлэлцэн, зөвшилцсөний үндсэн дээр өөрчилнэ.
  - 1.2. Бүх хувцас хэрэгслийг хийсэн эсвэл түүнд орсон материал бүр нь хүний биед сөрөг нөлөөгүй, аливаа цочрол, шархлаа үүсгэхээргүй, биений хөлстэй урвалд орох чанаргүй зориулалтын хувцасны материалаар хийгдсэн байна.
  - 1.3. Тусгай зориулалтын ажлын хувцас, хантааз, халадны энгэрийн зүүн дээд талд компанийн логотой байна. Ар талын дээд хэсэгт “**МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК**” гэсэн бичээстэй байна.
  - 1.4. Тусгай зориулалтын ажлын хувцас нь ажилтны хүйс, өндөр, биений хэмжээ, гүйцэтгэх ажлын онцлог нөхцөлд тохирч, ажилтны аюулгүй байдлыг хангасан байх ёстой.
  - 1.5. Ширхэгийн бүтээгдэхүүн: 70-80% полиэстр, 20-30% хөвөн даавуу, нэхээсийн нягт 200г/м.кв багагүй, агаар нэвтрүүлэх чадвар 60 дм3/м<sup>2</sup>-с багагүй, уур нэвтрүүлэх чадвар 40г/м.кв-аас багагүй, угаасны дараах өөрчлөлт ±3.5%-иас ихгүй байна.
  - 1.6. Будгийн тогтвортой: Угаалга болон үрэлтэнд тэсвэртэй / 4-5 балл /
  - 1.7. Хувцасны материал нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, ашиглалтын температур -30°C-аас +40°C байх бөгөөд ажлын хувцасны зориулалтаар ашиглах боломжтой байна.

- 1.8. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсэг, өвдөгний доод хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна.
- 1.9. Гадуур хувцсыг өмсөх, тайлахад хялбар байлгах, дотор талд өмссөн хувцастай барьцалдахгүй байлгах зориулалт бүхий материал ашиглан хийсэн байна.
- 1.10. Дотор нь гэлгэр гадаргуу үүсгэн нэхсэн даавуу байна
- 1.11. Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химиин аргаар цэвэрлэх боломжтой байна.
- 1.12. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас, өндөрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой, дээш авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байна.
- 1.13. Ажилтны биеийн онцлогоос хамаарч стандарт хэмжээнээс өөр бол ажилтны бодит хэмжээг заавал авч захиалгыг гүйцэтгэнэ.
- 1.14. Тусгай зориулалтын ажлын хувцас нь өвөл болон зуны улиралд өмсөх хоёр төрөл байна.

## **2. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ЗУНЫ АЖЛЫН ХУВЦАСНЫ ЗАГВАР:**

- 2.1 Хүрэм нь эргэдэг, босоо захтай байх ба 0,5см-н оёдолтой байна.
- 2.2 Ханцуй нь манжетттай байна.
- 2.3 Хүрэмний энгэр нь 8 номерын трактор цахилгаантай, энгэрийн цахилгааныг дарсан даравч /планктай/ байна. Даравч /планк/ нь кнопон товchoор товчлогддог байна.
- 2.4 Хүрэм нь малгайтай байх ба их биеэс цахилгаанаар салдаг байна.
- 2.5 Хүрэмний дээд хэсгийн хосолгоо өнгө нь мөрний дээд хэсгээс доош 27-30см байна. Хүрэмний ар, энгэрийн хосолгоо өнгө болон үндсэн өнгөний залгаан дээр 5см-н гэрэл ойлгогчийг оёсон байна.
- 2.6 Энгэрийн дээд хэсэгтээ 2 тагтай халаастай байна.
- 2.7 Хүрэмний доод талд нь ил 2 халаастай байх ба халаасны өндөр 19см, өргөн 18см хэмжээтэй байна. Халаасны амсарыг 2см нугалж оёно.
- 2.8 Хүрэмний энгэрийн доод халаасны таг нь 6,5см өргөнтэй хосолгоо өнгөөр хийнэ. Уг таг нь кнопон товchoор товчлогддог байна.
- 2.9 Энгэрийн доод халаас нь урд болон доод хэсгээрээ хосолгоо хөндийрүүлэгчтэй байна.
- 2.10 Хүрэмний суга хэсгээр агааржуулагч гуурс хадна.
- 2.11 Хүрэм нь доод талаараа манжетттай байна. Томсгож багасгах зориулалтын сойлттой байна.
- 2.12 Хүрэмний энгэрийн зүүн халаасны дээд талд Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн логотой байна. Ар талын дээд хэсэгт "МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК" гэсэн бичээстэй байна.
- 2.13 Хүрэм нь голоороо чангалаагч бүстэй байна.
- 2.14 Өмдний суудал хэсэг, өвдөг хэсэг нь давхар оруулгатай байна.
- 2.15 Өмдний өвдөг нь 2 ширхэг танаастай байх ба энэ нь хөдөлгөөн чөлөөлөх ач холбогдолтой.
- 2.16 Өвдөгний давхарлагааны доод талаас доош 1,5см зайд 5 см-н өргөнтэй гэрэл ойлгогчийг 2 эгнээ өмдний урд хэсэгт оёно.
- 2.17 Өмд нь урд 2 талдаа ил халаастай байх ба баруун гуяны хэсэгт өвдөгнөөс дээш хэсэгт мөн ил халаастай байна. Ил халаас нь хосолгоо өнгөөр хөндийрүүлэгч хийсэн байна.

- 2.18 Өмдний бүс нь 5 ширхэг түдүүлтэй. Урдаа нэг ширхэг товчтой байна.
- 2.19 Өмдний шуумгийг 1,5-2см нугалж оёно. Ташаа, халаасны амсарыг 2см нугалж , 0,1см хэмжээтэй оёно.
- 2.20 Өмдний бүх түдүүл, суудлавчны булан бүр, халаас, халаасны таг г.м хэсгүүдэд тусгай зориулалтын машинаар бөхөлгөө хийнэ.
- 2.21 Инженерээс дээш албан тушаалтын ажлын тусгай хувцасны материалын оруулгын өнгө нь ажилтнуудын сонгосон өнгөнөөс өөр байна.
- Хавсралт 1-д ерөнхий инженер, ашиглалтын менежер болон бүх түвшний инженерүүдүүн тусгай зориулалтын зуны ажлын хувцасны ерөнхий загварын харагдах байдлыг ард, урд талаас нь жишиг зургаар харуулав.
- Хавсралт 2-д техникч, кабельчин бусад мэргэжлийн ажилтнуудын тусгай зориулалтын зуны ажлын хувцасны ерөнхий загварын харагдах байдлыг ард, урд талаас нь жишиг зургаар харуулав.

### **3. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ӨВЛИЙН АЖЛЫН ХУВЦАСНЫ ЗАГВАР:**

- 3.1 Хүрэмний дулаалгыг 1мкв-дад 280-300гр-тэй ширмэл синтафон эсвэл түүнтэй дүйцэхүйц материалыаар хийнэ.
- 3.2 Хүрэмний малгай нь ширмэл синтафон дотортой, их биенээс 5 номерийн цахилгаан товчоор салдаг байна.
- 3.3 Хүрэм нь дотроо салдаг давхар дотортой байх ба уг дотор нь 1мкв-даа 200гр-тай 2 талдаа өнгө материалыаар ширсэн ширмэл, эсвэл түүнтэй дүйцэхүйц материалыаар хийнэ. Их биений үндсэн дотроос 5 номерийн цахилгаан товчоор салдаг байна.
- 3.4 Хүрэм нь босоо, үстэй захтай, малгайтай байна. Малгай нь цахилгаанаар салдаг байна.
- 3.5 Хүрэмний ханцуйны үзүүр хэсгийг 2-2,5 см-р нугалж 0,1 см-р оёх ба дотор талдаа сүлжмэл манжеттэй байна. Энэ нь салхи сийгэхээс хамгаална.
- 3.6 Хүрэмний энгэрийн дээд хэсэгт болон цээжний арын хэсэгт гэрэл ойлгогч бүхий хөндлөн оруулга оруулсан байна.
- 3.7 Хүрэм нь залгаа ханцуйтاي байна.
- 3.8 Хүрэмний энгэр нь 8 номерын трактор цахилгаантай, энгэрийн цахилгааныг дарсан даравчтай / планктай/ байна. Даравч нь /планк нь/ кнопон товчоор товчлогддог байна.
- 3.9 Хүрэм нь энгэрийн дээд хэсэгтээ 2 тагтай халаастай байна.
- 3.10 Хүрэмний доод талд нь ил 2 халаастай байх ба халаасны өндөр 19см, өргөн 18см хэмжээтэй байна. Халаасны амсарыг 2см нугалж оёно.
- 3.11 Хүрэмний энгэрийн доод халаасны таг нь 6,5см өргөнтэй хосолгоо өнгөөр хийнэ. Уг таг нь кнопон товчоор товчлогддог байна.
- 3.12 Энгэрийн доод халаас нь урд болон доод хэсгээрээ хосолгоо хөндийрүүлэгчтэй байна.
- 3.13 Хүрэмний энгэрийн зүүн халаасны дээд талд Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн логотой. Ар талын дээд хэсэгт "МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК" гэсэн бичээстэй байна.
- 3.14 Хүрэм нь голоороо чанглагч бүстэй байна.
- 3.15 Хүрэмний суга хэсгээр агааржуулагч гуурс хадна.
- 3.16 Өмд нь бүс хэсгээрээ 10см өргөнтэй, ар хэсгээрээ 15-18см өндөртэй байна.
- 3.17 Өмдний суудал хэсэг, өвдөг хэсэг нь давхар оруулгатай байна.

- 3.18 Өмд нь урд 2 талдаа ил халаас, баруун гуяны хэсэгт өвдөгнөөс дээш хэсэгт ил халаастай байх ба хосолгоо өнгөөр хөндийрүүлэгч хийсэн .
- 3.19 Өвдөг нь 2 ширхэг танаастай байх ба энэ нь хөдөлгөөн чөлөөлөх ач холбогдолтой.
- 3.20 Өвдөгний давхарлагааны доод талаас доош 1,5см-д 5 см-н өргөнтэй гэрэл ойлгогчийг 2 эгнээ урд хэсэгт оёно.
- 3.21 Өмдний бүс нь 5 ширхэг түдүүлтэй. Урдаа нэг ширхэг товчтой байна.
- 3.22 Өмдний шуумгийг 1,5-2см нугалж оёно. Ташаа карманы амсарыг 2см нугалж 0,1см хэмжээтэй оёно.
- 3.23 Өмдний бүх түдүүл, суудлавчны булан бүр, халаас, халаасны таг г.м хэсгүүдэд тусгай зориулалтын машинаар бөхөлгөө хийнэ.
- 3.24 Инженерээс дээш албан тушаалтны ажлын тусгай хувцасны материалын оруулгын өнгө нь ажилтнуудын сонгосон өнгөнөөс өөр байна.

Хавсралт 3-д ерөнхий инженер, ашиглалтын менежер болон бүх түвшний инженерүүдүүд тусгай зориулалтын өвлүүлийн ажлын хувцасны ерөнхий загварын харагдах байдлыг ард, урд талаас нь жишиг зургаар харуулав.

Хавсралт 4-д техникч, кабельчин бусад мэргэжлийн ажилтнуудын тусгай зориулалтын өвлүүлийн ажлын хувцасны ерөнхий загварын харагдах байдлыг ард, урд талаас нь жишиг зургаар харуулав.

#### **4. АЖЛЫН ХАНТААЗ /ЖИЛЕТ/ ЗАГВАР:**

- 4.1 Хантааз нь ажлын хүрэмний өнгөтэй адил өнгөтэй байна.
- 4.2 Хантаазны энгэр нь 8 номерын трактор цахилгаан товчтой байна.
- 4.3 Хантаазны зүүн энгэрийн дээд хэсэгт 1, баруун энгэрийн дээд хэсэгт 2 ил халаастай байна.
- 4.4 Хантаазны зүүн, баруун талын доод хэсэгт ил халаастай, халаас бүр товчилдог даравчтай байна.
- 4.5 Хантаазны энгэрийн зүүн дээд хэсэгт МХС ХХК-ийн лого байна.
- 4.6 Хантаазны цээжний хэсэгтээ болон нурууны хэсэгтээ гэрэл ойлгогч бүхий оруулга оруулсан байна.

Хавсралт 5-д ажлын хантаазны ерөнхий загварын харагдах байдлыг ард, урд талаас нь жишиг зургаар харуулав.

#### **5. АЖЛЫН ХАЛАДНЫ ЗАГВАР:**

- 5.1 Ажлын халад нь цайвар цэнхэр өнгөтэй байна.
- 5.2 Ажлын халад нь хагас богино урттай байна.
- 5.3 Ажлын халад нь хошуу бартаа захтай, урдуураа задгай, товчтой байна.
- 5.4 Ажлын халадны зүүн энгэрийн дээд хэсэгт МХС ХХК-ийн лого байна.
- 5.5 Ажлын халадны энгэрийн доод хэсэгт хоёр ил халаастай байна.
- 5.6 Ажлын халадны өвөр, ар талдаа хэв загвар гаргасан залгаас оёдолтой байна.
- 5.7 Эрэгтэй ажилтны халад нь галбир гаргасан залгаас оёдолгүй байна.
- 5.8 Ажлын халадны ханцуй нь 2 см өргөн манжетттай байна.
- 5.9 Ажлын халадны ханцуй нь хагас богино загвартай байна.

Хавсралт 6-д ажлын халадны ерөнхий загварын харагдах байдлыг ард, урд талаас нь жишиг зургаар харуулав.

#### **6. ҮЙЛЧЛЭГЧИЙН АЖЛЫН ӨМД ЦАМЦНЫ ХОСЛОЛ:**

#### **А. Үйлчлэгчийн цамцны загвар**

- 6.1 Ажлын цамц нь тод цэнхэр өнгөтэй байна.
- 6.2 Ажлын цамц нь дугуй захтай байна.
- 6.3 Ажлын цамц нь дан зөрлөгтэй байна.
- 6.4 Ажлын цамц нь хагас богино загвартай байна.
- 6.5 Ажлын цамцны энгэрийн доод хэсэгт ташааны оёдолд оруулсан ил халаастай байна.
- 6.6 Ажлын цамцны энгэрийн зүүн дээд хэсэгт МХС ХХК-ийн логотой байна.
- 6.7 Ажлын халадны ханцуй нь хагас богино загвартай байх ба 2 см өргөн манжеттай байна.

#### **Б. Үйлчлэгчийн өмдний загвар:**

- 6.8 Ажлын өмд нь шулуун загвартай хар өнгөтэй байна.
- 6.9 Ажлын өмдний дээд хэсэгт монжаттай байна.

Хавсралт 7-д үйлчлэгчийн ажлын өмд цамцны ерөнхий загварын харагдах байдлыг ард, урд талаас жишиг нь зургаар харуулав.

#### **7. БАГЛАА, БООДОЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 7.1 Хувцас тус бүрийг (хос бол иж бүрдүүлж) тусгай зориулалтын гялгар уутанд размер тус бүрээр савлан хэд хэдээр нь багцалж хайрцаглана.
- 7.2 Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, үйлдвэрлэгчийн нэр хаяг, огноог бичсэн дагалдах хуудастай байна. Дагалдах хуудсыг 2 хувь бичиж 1 хувийг өгнө.
- 7.3 Хайрцагны хажуу талд ус, чийгнээс хамгаалахыг анхааруулсан таних тэмдгийг тод өнгөөр тэмдэглэсэн байна.

Зуны ажлын хувцас

Хавсралт 1  
/Жишиг зураг/



Урд талаас  
харагдах байдал

Ар талаас  
харагдах байдал

Зуны ажлын хувцас

Хавсралт 2  
/Жишиг зураг/



Урд талаас  
харагдах байдал

Ар талаас  
харагдах байдал

Өвлийн ажлын хувцас

Хавсралт 3  
/Жишиг зураг/



Урд талаас  
харагдах байдал

Ар талаас  
харагдах байдал

Хавсралт 4  
/Жишиг зураг/

Өвлийн ажлын хувцас




Урд талаас  
харагдах байдал

Ар талаас  
харагдах байдал

Ажлын хантааз

Хавсралт 5  
/Жишиг зураг/



Урд талаас  
харагдах байдал

Ар талаас  
харагдах байдал

Хавсралт 6  
Ажлын халад  
/Жишиг зураг/



Урд талаас  
харагдах байдал



Ар талаас  
харагдах байдал

Ажлын өмд цамц

Хавсралт 7  
/Жишиг зураг/



Урд талаас  
харагдах байдал



Ар талаас  
харагдах байдал